



# Цэнхэр дэлхий ногоон амьдрал

Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол  
Багшийн гарын авлага

Ембүүгийн Батчулуун  
Гэцэлийн Уранчимэг



# ЦЭНХЭР ДЭЛХИЙ НОГООН АМЬДРАЛ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН БОЛОВСРОЛ  
БАГШИЙН ГАРЫН АВЛАГА



УЛААНБААТАР

## Цэнхэр дэлхий ногоон амьдрал .

ННА 74  
ДАА 370  
Б-10

ЦЭНХЭР ДЭЛХИЙ, НОГООН АМЬДРАЛ  
Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол. Багшийн гарын авлага

Зохиогч: Е.Батчулуун, Г.Уранчимэг  
Редактор: Х.Цогбадрал, С.Хадбаатар  
Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Сэрээтэр  
Хавтасны зургийг: Kids tokei: <http://www.kids-tokei.com/snapeee/>  
  
Цаасны хэмжээ: 172 ч 245 1/10  
Хуудасны тоо: 132

@2024, Ембүүгийн Батчулуун

Зохиогчдын зөвшөөрөлгүйгээр номыг бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлах, бүтэц, загварыг ашиглах, гадаад хэл рүү орчуулах, дахин хэвлэх, цахим болон бусад хэлбэрээр ашиглахыг хориглоно.

**ISBN: 978-9910-0-2213-6**

ЮНЕСКО-гийн 2022–2023 оны Оролцооны хөтөлбөрийн санхүүжилтээр хэвлэв.

Энэ номонд оруулсан жишээ баримт НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага-ЮНЕСКО-гийн байр суурийг илэрхийлээгүй бөгөөд зөвхөн зохиогчдын үзэл бодол болно.

Номын талаарх санал хүсэлтээ дараах хаягаар ирүүлбэл талархан хүлээн авах болно.

Монголын газарзүйн боловсролын нийгэмлэг

Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим

Бага тойруу-14

Улаанбаатар-210648

Утас:+976-70119554

Гар утас: +976-99091640

E-mail:[batchuluun@msue.edu.mn](mailto:batchuluun@msue.edu.mn)

website:[www.geoforum.mn](http://www.geoforum.mn)

Эшлэл авах: Батчулуун, Е., Уранчимэг, Г. (2024). Цэнхэр дэлхий, ногоон амьдрал: Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол. Улаанбаатар. Мөнхийн үсэг ХХК. 132 х.

Citation: Yembuu, B., Getsel, U. (2024). *The Blue Earth and The Green Life. Climate Change Education. Teacher's Manual* Ulaanbaatar. Munkhiin Useg printing. 132 pages.

Published with the financial support of the UNESCO PARTICIPATION PROGRAMME for the years 2022–2023.

The content of this book, including case studies, does not necessarily reflect the official position of UNESCO. The views expressed are solely those of the authors.

## ӨМНӨХ ҮГ

Орчин үед дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлуудын нэг нь уур амьсгалын өөрчлөлт юм. Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлт (human induced climate change) гэсэн ойлголт бий боллоо. Энэ нь хүний хүчин зүйлээс шууд болон дам шалтгаалсан өөрчлөлтийг хэлнэ. Тухайлбал, малтмал түүшний шаталт, ойн түймэр зэргээс болоод хүлэмжийн хийн ялгаралт ихсэх, хотжилт, ой, газар ашиглалтаас болж ургамал, газрын бүрхэвч доройтох, ингэснээр дэлхийн гадаргын альбедо өөрчлөгдөх, байгалийн усны эргэлтийн горим алдагдах, хотын дулааны арлын нөлөөлөл буй болох зэрэг нь уур амьсгалыг өөрчилдөг. Өнөө үеийн дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан нь бид өөрсдөө учраас шийдвэрлэх арга зам нь ч биднээс хамаарна. Иймд бид өөрсдөө, бидний сурагчид, эцэг эх, бусад хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийн шалтгааныг ойлгож мэдэх нь түүнийг сааруулах, дасан зохицож амьдрах арга замд суралцах, хэрэгжүүлэх явдал болно.

ЮНЕСКО-гоос УАӨ-ийн боловсролыг багшийн боловсролд нэвтрүүлэх нь ихээхэн чухал хэмээн үзэх боллоо. Учир нь багш бол нийгмийг өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч уур амьсгалын өөрчлөлтийн талаар багш наарт зориулсан материал нэн хомс, ганц нэг төсөл хөтөлбөрийн хүрээнд гаргасан гарын авлагад энэ талаар тусгахдаа онолын ойлголт голлосон, сургалтад ашиглахад шаардлага хангахгүй байгаа нь практикаас харагдаж байна.

Сургалтаар дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол олгох нь хувь хүний болон нийгмийн хариуцлагын чухал хэсэг бөгөөд дасан зохицох арга барил эзэмшүүлснээр ухамсартай, хариуцлагатай иргэн бэлтгэх явдал юм. Хичээлийн агуулга, арга зүйд уур амьсгалын өөрчлөлтийн талаар тусган оруулах нь сурагчдад түүний серег үр дагаврыг даван туулахын тулд байгаль орчинд хэрхэн хандах, хэрхэн хамтарч, хариуцлага хүлээх ёстойг заана гэсэн үг юм.

УАӨ-ийн боловсролын үзэл баримтлалыг багш наарт ойлгуулж, чадавхийг хөгжүүлэх зорилгоор багш нарын эрэлт хэрэгцээнд нийцсэн, өдөр тутмын амьдралын жишээнд тулгуурлан идэвхтэй үйл ажиллагаа явуулах замаар сургалтад ашиглах боломж бүхий энэхүү гарын авлагыг Монголын газарзүйн боловсролын нийгэмлэгээс бэлтгэн гаргаж байна.

Ембүүгийн Батчулуун

Доктор (Ph.D), Профессор.МУБИС, Газарзүйн тэнхим



## АГУУЛГА

|   |    |
|---|----|
| <b>ОРШИЛ</b>  | 6  |
| <b>БҮЛЭГ 1 Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол</b>                            | 1  |
| 1.1. Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол гэж юу вэ?                           | 12 |
| 1.2. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар суралцахуйн зорилтууд                   | 14 |
| 1.3. Уур амьсгалын өөрчлөлтийн боловсролын үндсэн зарчмууд                    | 15 |
| 1.4. Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол олгоход багшийн үүрэг                | 16 |
| 1.5. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх багшийн мэдлэгийн хүрээ                | 18 |
| 1.6. Уур амьсгалын өөрчлөлтэй холбоотой ташаа ойлголт                         | 20 |
| <b>БҮЛЭГ 2. Цаг агаар ба уур амьсгал, ялгаа</b>                               | 23 |
| 2.1. Агаарын найрлага, шинж чанар   | 24 |
| 2.2. Нэмэлт мэдээлэл: Озоны цоорхой гэж юу вэ?                                | 25 |
| 2.3. Цаг агаар ба уур амьсгалын ялгаа   | 26 |
| 2.4. Нэмэлт мэдээлэл: Цаг агаарын элементүүд                                  | 27 |
| 2.5. Уур амьсгал бүрэлдэн тогтоход нөлөөлдөг хүчин зүйлс                      | 31 |
| 2.6. Уур амьсгал ба уламжлал  | 33 |
| <b>БҮЛЭГ 3. Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан</b>                            | 35 |
| 3.1. Уур амьсгалын өөрчлөлт ба түүний шалтгаан                                | 36 |
| 3.2. Монгол орны уур амьсгалын өөрчлөлт                                       | 39 |
| 3.3. Нэмэлт мэдээлэл: Хүлэмжийн хий гэж юу вэ?                                | 41 |
| 3.4. Хүлэмжийн нөлөө  | 42 |
| 3.5. Хүлэмжийн хийн эх үүсвэр   | 44 |
| <b>БҮЛЭГ 4. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, үр дагавар</b>                   | 45 |
| 4.1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ба үр дагавар                            | 46 |
| 4.2. Нэмэлт мэдээлэл: Хүчиллэг тунадас гэж юу вэ?                             | 52 |
| 4.3. Уур амьсгалын өөрчлөлт ба жендер   | 55 |
| 4.4. Уур амьсгалын өөрчлөлт ба эрүүл мэнд                                     | 56 |
| 4.5. Нэмэлт мэдээлэл: Агаар дахь РМ гэж юу вэ?                                | 59 |
| <b>БҮЛЭГ 5. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах ба дасан зохицох арга зам</b> |    |
| 5.1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах                                      | 62 |
| 5.2. Эрчим хүч хэмнэх   | 64 |
| 5.3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй                                 | 66 |
| 5.4. Экологийн мөр  | 68 |
| 5.5. Нуурстөрөгчийн мөр   | 70 |
| 5.6. Усны мөр   | 72 |
| 5.7. Дам зарцуулагдсан ус   | 76 |
| 5.8. Хог хаягдал, ялгах, дахин ашиглах  | 77 |
| 5.9. Нэмэлт мэдээлэл: Экосистемийн үйлчилгээ                                  | 79 |

|  |     |
|--|-----|
| <b>БҮЛЭГ 6. Сургалтын арга зүй, үйл ажиллагаа, үнэлгээ</b>                 | 81  |
| <b>Сургалт, үйл ажиллагаанд уур амьсгалын өөрчлөлтийн талаар тусгах нь</b> | 82  |
| Арга зүй 1. Хамаарлын зураглал   | 83  |
| Арга зүй 2. Тохиолдсон жишээ ашиглах                                       | 84  |
| Арга зүй 3. Кейс судлал  | 87  |
| Арга зүй 4. Дурд тоглох  | 89  |
| Арга зүй 5. Туршилт хийх   | 89  |
| Арга зүй 6. Цахим эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, ашиглах                | 90  |
| Жишээ А. Хүлэмжийн хийн ялгаруулалт  | 90  |
| Жишээ Б. Усны мөрийг тооцоолох   | 93  |
| Жишээ В. Хуванцрын хэрэглээнээс үүсэх бохирдол                             | 94  |
| <b>Сургалтад ашиглах үйл ажиллагаа</b>                                     |     |
| Үйл ажиллагаа 1. Уламжлалт мэдлэг, зан заншлыг судлах                      | 95  |
| Үйл ажиллагаа 2. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах                         | 96  |
| Үйл ажиллагаа 3. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, үр дагавар               | 98  |
| Үйл ажиллагаа 4. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хувь нэмэр            | 98  |
| Үйл ажиллагаа 5. Ус хэмнэх шалтгаан, дуслын усалгаа                        | 99  |
| Үйл ажиллагаа 6. Би хэр их ус хэмнэгч вэ?                                  | 100 |
| Үйл ажиллагаа 7. Миний хэрэглээ ба усны мөр                                | 102 |
| Үйл ажиллагаа 8. Савласан усны хэрэглээг багасгах                          | 103 |
| Үйл ажиллагаа 9. Усны мөрөө багасгах боломж бий юу?                        | 104 |
| Үйл ажиллагаа 10. Ухаалаг худалдан авалт                                   | 104 |
| Үйл ажиллагаа 11. Нигшингэ (компост) бэлтгэх                               | 105 |
| Үйл ажиллагаа 12. Сав, баглаа боодол, хаягдал                              | 107 |
| Үйл ажиллагаа 13. УАӨ-ийн эсрэг би ямар хувь нэмэр оруулж чадах вэ?        | 108 |
| Үйл ажиллагаа 14. Таны нүүрстөрөгчийн мөр юунаас хамаарах вэ?              | 109 |
| <b>Үнэлгээний жишиг даалгавар</b>  | 111 |
| Даалгавар 1. Цаг агаар ба уур амьсгалын ялгаа                              | 111 |
| Даалгавар 2. Агаарын температурын өөрчлөлтийг судлах                       | 111 |
| Даалгавар 3. Хүлэмжийн нөлөө   | 112 |
| Даалгавар 4. Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан                            | 114 |
| Даалгавар 5. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, үр дагавар                   | 115 |
| Даалгавар 6. Бэлчээрийн менежмент  | 117 |
| <b>ХАВСРАЛТ</b>  | 118 |
| А. Хүлэмжийн хийн талаар хичээлийн агуулгад тусгах жишээ                   | 118 |
| Б. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар хичээлийн агуулгад тусгах жишээ        | 119 |
| В. Хоол хүнсний усны мөрийг тооцоолоход ашиглах жишээ                      | 120 |
| Г. Усны мөр-Хувцас үйлдвэрлэл  |     |
| Үндсэн ухагдахууны тайлбар   | 124 |
| Ашигласан материал   | 127 |

## Зорилго

Энэхүү гарын авлагын зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар сургалтад нэвтрүүлэх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, дасан зохицоход шаардагдах мэдлэг, үр чадварыг сурагчдад олгох багш нарыг чадавхжуулах, ингэснээр сурагчдад ногоон амьдралын дадал хэвшүүлэхэд оршино.

## Зорилт

- Уур амьсгал ба түүний өөрчлөлтийн шалтгаан, нөлөө, үр дагаврын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд нэгтгэх, интеграцлах арга барил эзэмших;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чадвараа дээшлүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохын тулд сурагчдын нас, хичээлийн онцлогт тохирсон арга зүйг сонгон хэрэглэх чадвартай болох;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг сургуулийн хэмжээнд зохион байгуулах, сурагчдыг идэвхтэй татан оролцуулах;

## Гарын авлагын агуулга, бүтэц

Гарын авлага нь дараах бүлгүүд ба хавсралтаас бүрдэнэ. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол
2. Цаг агаар ба уур амьсгал, ялгаа
3. Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан
4. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, үр дагавар
5. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах ба дасан зохицох арга замууд
6. Сургалтын арга зүй, үйл ажиллагаа, үнэлгээ
  - Сургалтын арга зүй
  - Үйл ажиллагаа
  - Үнэлгээний жишиг даалгавар

Хавсралт: Үндсэн ухагдахууны тайлбар

## Гарын авлага хэнд зориулагдсан бэ?

- Бүх түвшний боловсролын багш нар: Цэцэрлэг, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд сургалт явуулдаг, төрөл бүрийн мэргэжлийн багш нар гол хэрэглэгчид болно.
- Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулагчид, сурх бичиг

# 1

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН БОЛОВСРОЛ

Энэ бүлгийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн боловсролын зорилго, зарчим, хэрэгцээ, шаардлага, ач холбогдол болон багшийн уурэг хариуцлагын талаар ерөнхий ойлголт эзэмшинэ.

### ТҮЛХҮҮР ҮГС

|  |   |
|--|---|
| Climate  | Уур амьсгал   |
| Climate change                                       | Уур амьсгалын өөрчлөлт                                |
| Climate change adaptation                            | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох                |
| Climate change education                             | Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол                   |
| Climate change literacy                              | УАӨ-ийн суурь мэдлэг                                  |
| Climate change mitigation                            | Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах                   |
| Content knowledge on climate change- CKCC            | УАӨ-ийн талаарх агуулгын мэдлэг                       |
| Pedagogical knowledge on climate change- PKCC        | УАӨ-ийн талаарх арга зүйн мэдлэг                      |
| Pedagogical and content knowledge on CC- PCKCC       | УАӨ-ийн талаарх агуулга-арга зүйн мэдлэг              |
| Technological Pedagogical and Content on CC- TPACKCC | УАӨ-ийн талаарх агуулга, арга зүй, технологийн мэдлэг |

## 1.1. Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол гэж юу вэ?

Нэгэнт “нүдэнд харагдаж, гарг баригдахуйц” болсон уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах гол “зэвсэг” бол боловсрол хэмээн ЮНЕСКО-гоос тодорхойлж “*Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол*” (*Climate Change Education*)<sup>1</sup>-ыг тэргүүлэх чиглэлээ болгон зарласан. Энгийнээр хэлбэл, уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэг, ойлголт эзэмшиж, амьдралдаа хэрэгжүүлснээр түүний сөрөг нөлөө, үр дагаврыг сөрөн туулна чадна. Иймд дэлхийн улс орнууд УАӨ-ийн боловсролд ихээхэн анхаарч, бүх түвшний сургалт, түүний дотор багш бэлтгэх, давтан бэлтгэх сургалтад нэвтрүүлэхийг чухалчилж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол олгох хоёр үндсэн арга зам нь *сааруулах ба дасан зохицох* явдал бөгөөд үүнийг 1) сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн талаар шинжлэх ухааны үндсэн мэдлэг олгох; 2) мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх замаар олгоно.

УАӨ-ийн боловсрол олгох нь сургалтын хэлбэр, агуулгаас үл хамаарах “салбар дундын”, хичээл хоорондын үйл явц юм. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс ангид орших улс орон, хүн үгүй, түүний нөлөөгөөр давтамж нь нэмэгдэж буй байгалийн гамшиг хэнийг ч ялгахгүй нь үнэн билээ. Иймд хүн бүрт уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол олгох, УАӨ-д дасан зохицох зан үйл төлөвшүүлэх нь хувь хүний төдийгүй нийгмийн хэрэгцээ болж байна.

НҮБ-ын мэдээгээр дэлхийн хүн амын 1.8 тэрбум нь 10-24 насны залуус бөгөөд УАӨ-ийн нөлөөгөөр ирээдүйд гарч болзошгүй сөрөг үр дагаврын эринд амьдрах үеийнхэн болно. Иймд ирээдүй хойч үеийнхэнд уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол олгосноор байгаль орчинд ээлтэй амьдралын хэв маяг, зан үйл төлөвшихөд нь тусалж, УАӨ-ийн үр дагаврыг даван туулах шийдвэр гаргахдаа хариуцлагатай хандах, дасан зохицож амьдрах хандлагыг бий болгоно.



Батчулуун, Е. (2018). Уур амьсгалын өөрчлөлт ба боловсрол. Геофорум сэтгүүл 2018. № 01




<sup>1</sup> The UNESCO Strategy for Action on Global Climate Change: <http://www.unesco.org>

## 1.2. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар

### суралцахуйн зорилтууд

ЮНЕСКО-гоос уур амьсгалын өөрчлөлтийн талаар суралцахуйн зорилтыг 1) **танин мэдэхүйн**, 2) **нийгэм-сэтгэл хөдлөлийн**, 3)  **зан үйлийн** гэж 3 ангилан тус бүрд нь 5 зорилгыг тодорхойлжээ. Энэ нь сургалтад баримтлах үндсэн чиглэл болно.



Тогтвортой хөгжлийн зорилт (SDG-13): Уур амьсгалын орчлолт<sup>2</sup>

#### Суралцахуйн танин мэдэхүйн зорилт

1. Байгалийн гаралтай хүлэмжийн хий, түүний ач холбогдлыг мэдэх, ойлгох
2. Өнөөгийн УАӨ-ийн гол шалтгаан нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хүлэмжийн хийн ялгарал нэмэгдэж байгаа талаар ойлгож мэдэх
3. УАӨ-д хүний үйл ажиллагааны нөлөөг дэлхийн, үндэсний, орон нутгийн, өрх гэрийн болон хувь хүний гэхчлэн янз бүрийн түвшинд ойлгож, мэдэх
4. УАӨ-ийн экологийн, нийгмийн, соёлын болон эдийн засгийн үр дагавар нь орон нутгийн, үндэсний болон дэлхийн хэмжээнд нөлөөлөх ба харилцан адилгүйг ойлгох
5. Дэлхийн, орон нутгийн г.м өөр өөр хүрэнд илэрч буй УАӨ-ийг сааруулах, дасан зохицох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдэж, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулахтай холбон авч үзэх


#### Суралцахуйн нийгэм-сэтгэл хөдлөлийн зорилт

1. УАӨ-ийн үр дагавар байгаль орчин, нийгэм-эдийн засаг, соёл- зан үйлд илэрдэг болохыг тайлбарлаж чаддаг болох
2. УАӨ-ийн сөрөг үр дагавраас хамгаалахад бусдад дэмжлэг үзүүлж чаддаг байх
3. УАӨ-тэй тэмцэхэд бусадтай хамтрах, бүх нийтийн үйл хэрэгт оролцдог болох
4. УАӨ-ийн эсрэг хувь хүний оролцоо нь орон нутгийн түвшинд төдийгүй дэлхийн хэмжээнд ч нөлөөтэй гэдгийг ухаарч ойлгох
5. УАӨ-ийг бууруулахад хувь нэмэр оруулах нь хүн бүрийн үүрэг гэдгийг ухаарч ойлгох, өдөр тутам хийж байгаа үйлдлээ байнга үнэлж цэгнэдэг болох

#### Суралцахуйн зан үйлийн зорилт

1. Өөрийн ажил амьдрал, үйлдлээ уур амьсгалд ээлтэй байгаа эсэхийг үнэлж цэгнэх, алдаатай бол засаж залруулж чаддаг болох
2. УАӨ-ийн үр дагавраас болж зовж зүдэрсэн, нэрвэгдсэн хүмүүст тус дэм болох
3. Орон нутгийн, улс орны, өөрийн үйл ажиллагаа нь бусад хүмүүс, бусад газар нутагт ямар нөлөө үзүүлж болохыг урьдчилан тооцох, үнэлж цэгнэх, таамаглах чадвартай болох
4. УАӨ-өөс хамгаалах төрийн бодлогыг түгээн дэлгэрүүлэх чадвар эзэмших
5. Уур амьсгалд ээлтэй эдийн засгийн үйл ажиллагааг дэмждэг болох

<sup>2</sup> Education for Sustainable Development Goals: learning objectives: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000247444>



Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол: Мэдлэг, чадвар, хандлага (Эх сурвалж: Уранчимэг, Г. (2023). Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, хууд. 15)

## 1.6. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ташаа ойлголт

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон нийтийн дунд төдийгүй багш нарт ч ташаа ойлголт их байдаг. Заримаас дурдья.

**“Цаг агаар” ба “уур амьсгал”, цаг уур” гэсэн ойлголтыг ялгаа**

“Climate change” нь “уур амьсгалын өөрчлөлт” юм. “Цаг агаарын өөрчлөлт” гэх



нь буруу. Телевизийн мэдээгээр “НҮБ-аас дэлхийн цаг уурын өөрчлөлтийн талаар зохион байгуулсан хуралд манай улсаас .., Өнөөдөр дэлхийн цаг агаарын өөрчлөлт тулгамдсан асуудлын нэг болоод байна” гэх нь элбэг. Энэ нь “цаг агаар”, “уур амьсгал”, “цаг уур” гэсэн ойлголтыг хольж хутган хэрэглэж байгааг илтгэнэ. Ялгааг 2.2 хэсэгт дурдав. Цаг агаар бол богино хугацааны төлөв. Тухайлбал, өглөө нартай, өдөр тийш үүл гарч бороо ороонд, оройдоо сэргүүч, салхи шуурах зэргээр өдрийн дотор, цагийн доторх “өөрчлөлт” юм. Харин цаг агаар ингэж өөрчлөгдөхгүйгээр нэгэн хэвийн байдаг болчихвол ямар байх вэ? төсөөлөөд үз дээ. Зүйрлэвэл, өглөө босоход хүйтэн жихүүн үүлтэй байсан бол одоржингөө, хэдэн өдрийн турш, хэдэн сараар ч яг л ийм хэвээрээ, энэ нь даамжирсаар олон жилийн турш дандаа л хүйтэн жихүүн үүлтэй хэвээр байвал ямар байх билээ? Жам ёсоороо бол байнга өөрчлөгдөж байдаг цаг агаар ингээд өөрчлөгдөө больчихвол харин уур амьсгалын өөрчлөлт болно. Иймд “Climate change” гэдэг угийг “цаг агаарын өөрчлөлт” гэж ойлгож болохгүй.

**“Цаг уурын өөрчлөлт” гэх нь бүр ч буруу. Яагаад?**

Цаг уур гэдэг бол цаг агаар ба уур амьсгалын талаар судалдаг шинжлэх ухааны нэр юм. Англиар Meteorology, оросоор Метеорологи. Энэ салбарт ажилладаг, мэргэжилтэнг “Цаг уурч” (meteorologist) гэдэг. Хэрэв “Цаг уурын өөрчлөлт” гэж ярьж байгаа бол тухайн шинжлэх ухааны өөрчлөлтийн талаар ярьсан хэрэг болно.

## *Өндрийн озон ба газрын гадарга орчмын озоныг ялгах*

Озон нь 2 төрөл байна. “Өндрийн озон” гэдэг нь агаар мандалд газрын гадаргаас дээш 22-25 км-ийн өндөрт оршдог байгалийн гаралтай, нарны хэт яагаан туяаны хорт



*А.Өндрийн ба газрын гадарга орчмын озоны ялгаа, Б. Газрын гадарга орчмын “муу” озон уусех нь*

# 2

## ЦАГ АГААР БА УУР АМЬСГАЛ, ЯЛГАА

Энэ бүлгийн хүрээнд цаг агаар ба уур амьсгал, тэдгээрийн онцлог, амьдралын хэв маягт үзүүлэх нөлөө, агаарын найрлага, дэлхийн дулаарал ба УАӨ-ийн ялгааны талаар үндсэн ухагдахуун эзэмшинэ.

### ТҮЛХҮҮР ҮГС

|                               |                        |
|-------------------------------|------------------------|
| Climate                       | Уур амьсгал            |
| Climate change                | Уур амьсгалын өөрчлөлт |
| Climate science (climatology) | Уур амьсгал судлал     |
| Global warming                | Дэлхийн дулаарал       |
| Meteorology                   | Цаг уур                |
| Meteorologist                 | Цаг уурч               |
| Ozone hole                    | Озона цоорхой          |
| Weather                       | Цаг агаар              |
| Weather map                   | Цаг агаарын зураг      |

### Озоны өөр нэг төрөл

Агаар мандалд 22-25 км өндөрт орших озона давхаргын ач тусын талаар бид мэдэж авлаа. Агаарын бохирдлын улмаас газрын гадарга орчим озон үүснэ. Газрын гадарга орчим хуримтлагдах энэ озон нь агаар мандал дахь төрлөөсөө ялгаатай. Бохир агаарт орших озонаор амьсгалах нь бидний эрүүл мэндэд маш аюултай.



*Уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлгож мэдэхийн тулд юуны өмнө цаг агаар ба уур амьсгалын ялгааг мэдэх хэрэгтэй.*

### 2.3. Цаг агаар ба уур амьсгалын ялгаа

**Цаг агаар** бол тухайн газар, тухайн хугацаан дахь агаарын төлөв байдал бөгөөд температур, агаарын даралт, чийгшил, хур тунадас, салхи зэргээр тодорхойлогдоно. Цаг агаар газар бүр харилцан адилгүй, байнга өөрчлөгднө. Өглөө нартай байснаа өдөр тийш бүрхэж, бороо орно, оройдоо бороо арилж, тэнгэр дахин тогтуун болох зэргээр өдөртөө хэд хэдэн “хувирна”. Хэд хоногоор авч үзвэл, зарим өдөр нартай, заримдаа бүрхэг, хэдэн өдрийн турш бороо орж байснаа зогсож, нар гардаг. Өвөл зарим өдөр цасаар шуурч, заримдаа цэлмэгч тачигнасан хүйтэн болдог зэрэг нь цаг агаар юм. Ийнхүү цаг агаарыг хур бороо, салхи шуурга, наялаг, үүлтэй зэргээр нь хоногоор, долоо хоногоор, сараар урьдчилан тодорхойлдог.

Өдөр тутмын цаг агаар ямар байх, хэрхэн өөрчлөгдөх нь бидний амьдрал, ахуй, ажлын идэвх зэрэгт байнга нөлөөлдөг. Их халуун өдөр бие нозоорч, залхуу хүрдэг бол бороотой хуйсгануур, жихүүн өдөр гэрээс гарамгүй, сайхан борцтой цай уумаар санагдах нь бий. Олон хоног үргэлжилсэн бороо зогсож, тэнгэр гийх сайхан. Ийнхүү “тэнгэрийн ариншин” хэрхэн хувирч өөрчлөгддөгийг харуулдаг богино хугацааны доторх агаарын төлөв байдал нь цаг агаар болно. Цаг агаарыг судалдаг шинжлэх ухааныг цаг уурч бол энэ салбарын мэргэжилтэн, судлаач болно.

Өдөртөө бид ямар хувцас хунар өмсөхөө сонгохоос эхлээд хол ойр замд гарах эсэхээ шийдэхийн тулд цаг агаарын мэдээг бид сонирхдог.

| 5 хоногийн цаг агаарын мэдээ |       |        |       |        |        |        |
|------------------------------|-------|--------|-------|--------|--------|--------|
|                              | 23    | 24     | 25    | 26     | 27     |        |
| Бүрлт-Ухаа                   | <br>4 | <br>18 | <br>5 | <br>17 | <br>2  | <br>13 |
| Амгалан                      | <br>5 | <br>18 | <br>5 | <br>17 | <br>3  | <br>13 |
| Баганур                      | <br>2 | <br>19 | <br>2 | <br>18 | <br>1  | <br>14 |
| Тэрэлж                       | <br>1 | <br>18 | <br>1 | <br>17 | <br>-1 | <br>13 |
| Партизан                     | <br>5 | <br>18 | <br>5 | <br>17 | <br>3  | <br>13 |
| Өлзийт                       | <br>5 | <br>18 | <br>5 | <br>17 | <br>3  | <br>17 |

зүгийн дулаан агаарын масс “нүүж” ирсэн үед хэд хоногтоо аагим халуун цаг агаар ноёрхдог. Цаг агаарыг судалдаг шинжлэх ухаан нь цаг уур юм.

**Үүр амьсгал** гэдэг нь олон жилийн турш тогтсон цаг агаарын горим буюу дундаж нөхцөл байдал юм. Жишээ нь: Монгол оронд цаг агаар өдөр болгон, сар улирал бүр өөр байх боловч олон арван жилээр авч үзвэл ерөнхий нэг төлөв гарна. Тэр нь уур амьсгал болно. Уур амьсгалыг наад зах нь 30-50 жил, түүнээс цааших хугацаагаар авч үзэх ба ялгаа илрэх орон зайн хувьд ч том газар орныг хамарна. Жишээ нь:

“Улаанбаатарын цаг агаар” гэх болохоос Улаанбаатарын уур амьсгал гэхгүй. “Монгол орны уур амьсгал”, “Европын уур амьсгал”, “Зүүн Азийн уур амьсгал” гэхчлэн том талбайг хамран олон жилийн туршид тогтсон цаг агаарын дундаж үзүүлэлт нь уур амьсгал болно.

Тухайн газар орны уур амьсгалыг тодорхойлдог үндсэн хоёр үзүүлэлт нь агаарын дундаж температур ба хур тунадасны нийлбэр буюу дулаан ба чийгийн харьцаа юм. Жишээ нь: Монгол орны хамгийн хүйтэн I сарын дундаж температур  $-25^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан VII сарын дундаж температур  $+25^{\circ}\text{C}$ , жилийн тунадасны нийлбэр дунджаар 350 мм байдаг бол Бразилийн төв хэсэгт жилийн нийлбэр тунадас 2,000 мм, агаарын температур дунджаар  $+24^{\circ}\text{C}$  байдаг.



**Цаг агаар (Weather):** Богино хугацааны агаар мандлын төлөв байдал. Байнга, цаг үргэлж өөрчлөгднө. Температур, тунадас, салхи, үзэгдэл, чийг, даралт, үүлшил зэргийг хоногт 3 цагийн зайдтай хэмжиж урьдчилсан мэдээ гаргадаг.

**Үүр амьсгал (Climate):** Тухайн газар тогтсон цаг агаарын олон жилийн дундаж, наад зах нь 30-50 жил, түүнээс дээш хугацаан дахь агаарын температур ба хур тунадасны харьцаагаар тодорхойлогдоно. Халуун хуурай, дулаан чийглэг, хуурай сэруүн, хуурай хүйтэн г.м.

**Цаг уур (Meteorology):** Цаг агаарын үзэгдэл, элементүүдийг судалдаг шинжлэх ухаан. ХАА-н цаг уур, барилгын цаг уур, синоптик цаг уур зэрэг олон салбартай.

**Цаг уурч (Meteorologist)-** Энэ салбарт ажилладаг мэргэжилтэн.

## Цэнхэр дэлхий ногоон амьдрал .

болон хоолонд амт оруулагч бэлдэхдээ хээрийн өвс ургамал ашиглаж хэрэглэдэг уlamжлалтай.


Уlamжлалт зан заншил, нутгийн хүмүүсийн зан үйл, мэдлэг бол тухайн газар орныхоо онцлогт урт удаан хугацааны туршид тохирсон амьдрах аргыг илтгэдэг тул тэдгээрийг судлах, үргэлжлүүлэх, хадгалан үлдэх талаар ажил зохиох нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэж буй нэг хэлбэр болно. Энэ талаар **ҮЙЛ АЖИЛАГАА 1.2-ийг сургалтад ашиглаарай.**

Газар газрын уlamжлалт сууц хүн төрөлхтний соёлын хэсэг боловч уур амьсгалын нөхцөлд тохирсон “бүтээл” юм. Жишээ нь: Мөнхийн хүйтэн уур амьсгалтай Арктик буюу туйлын бүсийн Инуитууд (Гренланд, Канадын хойд хэсэг, Аляска) цасаар барьсан, бөмбөгөр хэлбэртэй *иглуу* (*Igloo*) гэх сууцанд амьдардаг. Бөмбөгөр хэлбэр нь дотроо дулааныг тогтоон барихад тустай ажээ.

Зүүн Өмнөд Ази зэрэг чийглэг, тропикийн уур амьсгалтай нутагт байнга хур бороотой, хөрсний гадарга нэн усархаг тул нутгийхан модон хөл дээр барьсан сууц “бүтээжээ”. Газраас дээш гарсан өндөр шонгийн хоорондуур ус чөлөөтэй нэвтрэн өнгөрөх тул сууц усанд автхааас хамгаалагдана.

Индонез болон Папуа Шинэ Гвинейн төв хэсгийн уулархаг нутгийнхны уlamжлалт сууц нь *Хонай* (*Honai*) юм. Ойролцоогоор 5-7 м өндөр, 4-6 м диаметр бүхий энэ сууц нь чийглэг мөнх ногоон ойн уур амьсгалд зохицсон, дээврийг нь дал модны навчаар, ханыг нь бамбоо modoор доторлосон байдаг.

Халуун, хуурай уур амьсгалтай нутгийнхан шавраар барьсан сууц “бүтээжээ”. Шаврыг хулс, зэгс зэрэгтэй хольж барьсан ийм сууц Мексикт элбэг. Африкийн халуун, чийглэг уур амьсгалтай газрынхан өвс, навчан дээвэртэй шавар ханатай сууцанд аж төрдөг нь сэргүүцүүлэх зориулалттай аж. Этиопийн өндөрлөг дэх хуурай бүсэд сууцны ханыг шавраар хийж, өвсөн дээвэртэй байдаг бол Африкийн өмнөд хэсгийн чийглэг нутгуудад сууцны хэлбэр дээвэр илүү бөмбөгөр болдог нь борооны ус тогтохгүйгээр шууд гулсан унахад зохицсон байна. Энэ нь Өмнөд Африк дахь Зулу үндэстний уlamжлалт сууц юм. Уүнтэй нэгэн адил хуурай, сэргүүн уур амьсгалтай манай орны уlamжлалт сууц нь эсгий гэр юм.



# 3

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ШАЛТГААН

Энэ бүлгийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн шатгаан болох хүлэмжийн нөлөө, хүлэмжийн хийн шинж чанар ба үүсэх эх үүсвэрийн талаар мэдлэг, ойлголт эзэмшинэ.

### ТҮЛХҮҮР ҮГС

Carbon dioxide  
Carbon emission  
Climate change  
Climate change causes  
Greenhouse gases  
Greenhouse effect  
IPCC  
Nitrogen oxide  
Ozone

Нүүрсхүчлийн хий (нүүрстөрөгчийн давхар исэл)  
Нүүрсхүчлийн хийн ялгаруулалт  
Уур амьсгалын өөрчлөлт  
Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан  
Хүлэмжийн хий  
Хүлэмжийн нөлөө  
УАӨ-ийн асуудлаарх ЗГХМХ  
Азотын исэл  
Озон




## Цэнхэр дэлхий ногоон амьдрал .

**Ойгүйжилт ба газрын бүрхэвчийн өөрчлөлт.** Мод ашиглах, тариалангийн талбай, бэлчээр бий болгох зэргээр дэлхий дээр жил бүр ойролцоогоор 12 сая га ойт устгадаг. Ойгүйжилт ба газар ашиглалт нь дэлхийн хэмжээгээр ялгарч буй хүлэмжийн хийн дөрөвний нэгийг эзэлнэ. Ой мод нүүрсхүчлийн хийг шингээдэг. Иймд мод огтлох нь тэр хэрээр агаар дахь хүлэмжийн хийн хэмжээ ихсэнэ гэсэн уг юм. Ой устган хот суурин барих, тариалан эрхлэх зэрэг нь дэлхийн гадаргын альбедо (нарны цацрагийг ойлгох чадвар) ба гадаргад шингэх цацрагийн хэмжээ, ууршилтын горим, хөрсний чийг хадгалах чадвар, хур тунадасны ус хөрсөнд нэвчих зэрэг үйл явцыг алдагдуулна.

**Тээвэр ашиглалт.** Ихэнх автомашин, онгоц, хөлөг онгоц шатмал түлшээр ажилладаг. Иймд тээврийн хэрэгсэл нэмэгдэх тутам хүлэмжийн хий, ялангуяа нүүрсхүчлийн хийн ялгаруулалт ихсэнэ. Ялангуяа бензин, дизель түлш ашигладаг машинаас ялгараах хорт утаанд азотын давхар исэл, аммиакийн хий, хүхрийн давхар исэл, метан зэрэг хүлэмжийн хий агуулагддаг.


**Хэт их хэрэглээ.** Дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтын голлох хэсгийг айл өрх, хувийн хэрэглээ эзэлнэ. Ажиллах, идэх, уух зэргээр бид амьдралынхаа туршид байгалийн нөөц, эрчим хүч ашиглаж, хог хаягдал гаргаж байдаг. Хувцас хунаар, цахилгаан бараа, хуванцар хэрэглэээ ихдэх тутам хүлэмжийн хийн ялгарал нэмэгддэг



Дэлхийн гадаргын  
дундаж температурын  
өөрчлөлт

(1901-2000 оны  
дундажтай харьцуулсан)


Эх сурвалж: NOAA  
Climate.com <https://www.climate.gov/news-features/understanding-climate/climate-change-global-temperature>



Агаар дахь хүлэмжийн хийн  
агууламж нэмэгдэх нь дэлхийн  
дундаж температур нэмэгдэх  
ундсэн шалтгаан болно.

### 3.4. Хүлэмжийн нөлөө

**Хүлэмжийн хий** (Greenhouse gases-GHG) гэдэг нь дэлхийн гадаргаас ялгарах урт долгионт цацрагийг (дэлхийн туяарал) барьж тогтоон (шингээн) дулаарал нэмэгдэхэд нөлөө үзүүлж байдаг байгалийн болон хүний үйл ажиллагааны гаралтай хийнүүдийг хэлнэ. Үүнд: нүүрсхүчлийн хий буюу нүүрстөрөгчийн давхар исэл ( $\text{CO}_2$ ), метан буюу намгийн хий ( $\text{CH}_4$ ), азотын давхар исэл ( $\text{N}_2\text{O}$ ), озон ( $\text{O}_3$ ), усны уур ( $\text{H}_2\text{O}$ ), гидрофторт нүүрстөрөгчүүд (HFCs), перфторот нүүрстөрөгчүүд (PFCs), гексафторт хүхэр (SF6) болон байгалийн бус гаралтай хлорфторнүүрстөрөгч (Chlorofluorocarbons-CFCs) орно. “Хүлэмжийн” гэж нэрлэгдэх эдгээр хийнүүд (CFC-ээс бусад) уг нь байгалийн замаар үүсэж, агаар мандалд оршин дулааныг тогтоон барьж байдаг. Хэрэв эдгээр хий байгаагүй бол дэлхийн гадаргын температур одоогийнхоос эрс хүйтэн, амьдрал оршин тогтоно нөхцөл бүрдэхгүй байх байв. Гэвч хүний үйл ажиллагааны нөлөөгөөр агаарт  $\text{CO}_2$ ,  $\text{CH}_4$ ,  $\text{O}_3$ , CFC,  $\text{NO}_2$  зэрэг хүлэмжийн хийн агууламж хэт ихэссэн нь байгалийн жамыг алдагдуулж, дэлхийн дулаарал нэмэгдэж байна. Үүнээс болж газрын гадарга орчмын агаарын температур нэмэгдэн байгаль-нийгэмд сөргөөр нөлөөлж буй үйл явцыг **хүлэмжийн нөлөө** (Greenhouse effect) гэнэ.



Тропосфер дахь хүлэмжийн хий нэмэгдсэн хэмжээ, харьцуулалт

| Хий                                  | 1750 оноос<br>өмнө | Одоо (2023 он) |
|--------------------------------------|--------------------|----------------|
| Нүүрсхүчлийн хий ( $\text{CO}_2$ )   | 280 ppm            | 415 ppm        |
| Метан ( $\text{CH}_4$ )              | 700 ppb            | 1800 ppb       |
| Азотын исэл ( $\text{N}_2\text{O}$ ) | 270 ppb            | 330 ppb        |
| Тропосферийн озон ( $\text{O}_3$ )   | 237 ppb            | 337 ppb        |

Аж үйлдвэрийн хувьсгалаас эхлэн үйлдвэрлэл, тээвэр, малтмал түлш (нүүрс, газрын тос, байгалийн хий г.м)-ний хэрэглээ, газар ашиглалт ихсэж, ойн бүрхэвч багассанаас болж агаар ялгаран гарах хүлэмжийн хий тасралтгүй нэмэгдсээр эдүгээ 400 ppm<sup>1</sup>-д хүрчээ.



Нэмэлт мэдээлэл:  
NASA Climate kids  
цахим хуудас

<sup>1</sup>ppm-parts per million-саяд ногдох хувь

# 4

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ, ҮР ДАГАВАР

Энэ бүлгийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ба үр дагавар нь нийгэм, эрүүл мэнд ба жендерийн асуудалд хэрхэн холбоотой талаар үзнэ.

### ТҮЛХҮҮР ҮГС

Climate change effect  
Climate change impact  
Climate change vulnerability  
Climate-related shocks  
Climate effects on health  
Food security  
Human-induced climate change  
Non point pollutant  
Point pollutant  
Water borne diseases

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө  
Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар  
Уур амьсгалын өөрчлөлтөд ортөмгийн байдал  
Уур амьсгалын хамаарлтай шок  
Эрүүл мэндэд уур амьсгалын нөлөө  
Хүнсний аюулгүй байдал  
Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй УАӨ  
Шууд бус бохирдуулагч  
Шууд бохирдуулагч (цэгэн буюу тодорхой)  
Усан гаралтай өвчин

Хүчиллэг тунадаснаас болж олон хөшөө дурсгал элэгдэлд ордгийн нэг жишээ нь Нью-Йорк хотноо байдаг алдарт эрх чөлөөний хөшөө юм. Бүр 17 дугаар зууны үед эрдэмтэд шохойн чулуу болон гантиг хөшөө элэгдэж, эвдэрдэг нь хүчиллэг шинж чанартай болсон агаарын нөлөө болохыг тогтоожээ. 1852 онд эрдэмтэн Роберт Смит агаарын бохирдол ба тунадасны холбоо хамаарлыг судлан “хүчиллэг тунадас” хэмээн нэрлэсэн түүхтэй.

#### 4.3. Уур амьсгалын өөрчлөлт ба жендер

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, үр дагавар жендерийн асуудалд хамаарна. Ялангуяа хөгжиж буй олон оронд эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх сул, боловсролын түвшин доогуур, гэр бүл, орон нутагтаа шийдвэр гаргахад оролцоо муу байдгаас гадна эмэгтэйчүүдийн амьжиргаа байгалийн нөөцөөс шууд хамааралтай байдаг нь тэднийг УАӨ-д илүү эмзэг, өртөмтгий байдлыг бий болгоно. Жишээ нь: УАӨ-өөс болоод хур тунадасны хэмжээ буурахад гол ус татарна, ширгэнэ, худгийн ундарга муудна, улмаар ширгэх зэргээр усны нөөц багасна. УАӨ нь жендерийн болон насны бүлгүүд дэх тэгш бус байдал нэмэгдэхэд нөлөөлнө. Тухайлбал, манай орны хувьд мал хариулах,mallах ажлын голыг үүрдэг хөдөөгийн хүүхэд, эмэгтэйчүүд УАӨ-ийн эрсдэлд хамгийн эмзэг хэсэг болдог. Эмэгтэй малчдын хувьд ган хуурайшилт их дарамт үзүүлнэ. Хөдөө аж ахуйн бүтээмж, хүнсний аюулгүй байдалд гарах өөрчлөлт ч эмэгтэйчүүдэд илүү тусна.

Усны хомсдол, усаар дутагдах нь охид, эмэгтэйчүүдийн ариун цэвэр, эрүүл ахуй, амьжиргаа ба орлогод нөлөөлнө. Хөгжиж буй орнуудад хөдөө аж ахуй, загас агуул зэрэг УАӨ-д эмзэг салбарт эмэгтэйчүүд ажиллах нь их. УАӨ-ийн нөлөөгөөр тэдний амьжиргаа тасалдах, орлогоо алдах зэргээр өртөх нь илүү байдаг. Ази, Африкийн буурай хөгжилтэй орнуудад ус зөөх нь голдуу эмэгтэй хүний ажил байдаг тул усны эх үүсвэр холдоход эмэгтэйчүүд, охидын ажлын ачаалал нэмэгдэнэ.




#### 4.5. Нэмэлт мэдээлэл: Агаар дахь PM гэж юу вэ?

Энэ нь нарийн ширхэгт тоосонцор бөгөөд PM (Particular Matter) гэж товчилдог. PM нь агаарын бохирдоос болж агаар үүссэн жижиг хэмжээтэй, хатуу юмуу шингэн хэсгүүд юм. Хэмжээ, найрлага, гарал үүслээр адилгүй боловч диаметрээр нь PM10 (10 микрометр ба түүнээс бага диаметртэй), PM2.5 (2.5 мкм ба түүнээс бага) гэж ангилна. 2.5 мкм нь 1 мм-ийг 400 хуваасантай тэнцэнэ. PM-ын хэмжээ бага байх тусам амьсгалын замын системд гүн нэвтэрдэг тул хүний эрүүл мэндэд хортой. Хөрсний хэсгүүд салхинд хийсэх, галт уулын дэлбэрэлт зэрэг байгалийн замаар үүсэх боловч хотын агаар дахь PM нь дулааны цахилгаан станц, уурын зуух, айлын болон машины яндангаас гарах утаанаас үүснэ. Улаанбаатарт өвлүүн улиралд агаарын нэмэгддэг нь бохирдлын гаралтай юм. Агаарт гарсан PM өөр бодистой дахин урвалд орж хоёр дагч бохирдуулагчид болно.

Улаанбаатар хотын агаар бохирдуулагч хамгийн түгээмэл бодисууд:


- Хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ )
- Азотын давхар исэл ( $\text{NO}_2$ )
- Том ширхэгт тоосонцор (PM10)
- Нарийн ширхэгт тоосонцор (PM2.5)
- Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)



Агаар дахь PM үүсэх уйл явц

Эх сурвалж: <https://energy.mit.edu/news/regulating-particulate-pollution-novel-analysis-yields-new-insights/>

Фотохимийн смог үүсэх явц



# 5

## ҮҮР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ БА ДАСАН ЗОХИЦОХ АРГА ЗАМ

Энэ бүлгийн хүрээнд үүр амьсгалын өөрчлөлтийг даван туулах 2 үндсэн арга зам болох сааруулах ба дасан зохицох арга зам, экологийн мөр (нүүрстөрөгчийн ба усны мөр г.м.)-ийн талаар судална.

### ТҮЛХҮҮР ҮГС

|                              |  |
|------------------------------|--|
| Ecological footprint         | Экологийн мөр                                |
| Carbon footprint             | Нүүрстөрөгчийн мөр                           |
| Climate change mitigation    | Үүр амьсгалын өөрчлөлтийг сааруулах          |
| Ecological disturbance       | Экологийн тэнцвэр алдагдах, экологийн хямрал |
| Ecological resilience        | Экологийн тэнцвэрт байдал                    |
| Ecosystem services           | Экосистемийн үйлчилгээ                       |
| Ecosystem-centred adaptation | Экосистемийн төвт дасан зохицохуй            |
| Rangeland degradation        | Бэлчээрийн талхагдал                         |
| Virtual water trade          | Дам зарцуулагдсан усны худалдаа              |
| Virtual water                | Дам зарцуулагдсан ус, дам ус                 |
| Water Footprint Calculator   | Усны мөрийн тооцоолуур                       |
| Water footprint              | Усны мөр                                     |

1 Footprint-“ул мөр” хэмээх “хадмал” орчуулга нь зохистой биш гэх үүднээс “мөр” гэсэн угзэр авах нь тохиromжтой гэж үзсэн болно.

### 5.3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй

*Дасан зохицох* гэдэг нь УАӨ-ийн нөлөөллийг багасгах, түүнд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтний хороо (IPCC)-оос уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох гэдэг нь “одоо болж буй болон болзошгүй үр дагавраас сэргийлэх үйл явц” хэмээн тодорхойлжээ. УАӨ-өөс гарч буй нөлөө ба үр дагавар, бэрхшээлийг багасгахын тулд уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийг бий болгох, усны нөөцийн менежментийн стратеги боловсруулах, экосистем, биологийн олон янз байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлэх зэрэг нь дасан зохицох арга хэмжээ юм.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах ба түүнд дасан зохицох арга зам нь хоорондоо харилцан хамааралтай үйл явц болно.

| Сааруулах  | Дасан зохицох  |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> <li>- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах</li> <li>- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжих</li> <li>- Эрчим хүчний хэмнэлт гаргах</li> <li>- Тогтвортой тээвэр ашиглалт</li> <li>- Ойжуулалт</li> <li>- Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- Дэд бүтцээ сайжруулах</li> <li>- Гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ</li> <li>- Усны нөөцийн менежмент</li> <li>- Экосистемд тшиглэсэн дасан зохицохуй</li> <li>- Уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуй</li> <li>- Нийгмийн эрүүл мэнд, уур амьсгалд дасан зохицох</li> </ul> |

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зарим жишээ дурдья.

- *Байгалийн гамишгаас сэргийлэх:* Үерээс хамгаалах далан босгох, усанд автаж болзошгүй голын татам, нуурын хөвөө зэрэг газар гэр байшин барихгүй байх г.м.
- *Хэт халуун ба хүйтнээс хамгаалах арга хэмжээ авах.*
- *Дэд бүтцээ сайжруулах.* Зам тавих, байшин барилга барихдаа цэвдгийн гэсэлтээс сэргийлэх, гадаргын хэлбэрийг сайтар тооцож, уруйн үер орж ирэхээргүй газрыг сонгох
- УАӨ-ийг сааруулахад сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, малтмал түлш (нуурс г.м) шатааж эрчим хүч үйлдвэрлэхийг бууруулах, ой мод, ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх
- *Mod тарих, ойг хамгаалах, газар ашиглалтыг сайжруулах.*
- *Гол, ус, худаг, булгийн эхийг хамгаалах*
- *Мал сүргийг зөв бутэцтэйгээр өсгөх:* Сүргийн бүтцийг зөв барьж, чанартай, цөөн тооны мал өсгөх нь олон мянган тонн хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулна. Мөн бэлчээрийн доройтол, ургамлын төрөл зүйл цөөрөх, хөрсний эвдрэлээс ч

улаан буудайгаар 790 г турил үйлдвэрлэнэ. Гурилаа исгэх, талхны зуурмаг бэлтгэх зэрэгт бас ус орно. Ийнхүү нэг кг талх бэлэн болоход 1,608 л ус зарцуулагдана. Талх үйлдвэрлэхэд шууд болон шууд бус замаар “шингэж” буй энэ усны хэмжээ нь усны мөр болно. Хавчуургатай талх (хамбургер) хийхэд орох ус арай их, 2,400 л болно.

**Ногоон усны мөр:** Газар тариалан, цэцэрлэгжүүлэлт зэрэгт ашиглаж буй хур тунадасны буюу борооны усыг хэлнэ. Ногоон ус нь хөрсөнд шингэж, ууршин агаарт гарч, эргээд тунадас болон бууна. Хур тунадасны усыг сайн ашиглаж чадвал голоос суваг татах, газар доорх усыг ашиглах шаардлага гарахгүй.



**Цэнхэр усны мөр:** Усалгаатай тариалан, аж үйлдвэр, ахуйн хэрэглээнд гол мөрөн, нуур зэрэг гадаргын болон газар доорх усны эх үүсвэрээс авч хэрэглэдэг цэвэр усны хэмжээ.



**Саарал усны мөр:** Үйлдвэрлэл ба ахуйн хэрэглээнээс гарсан бохирдуулагчийн зайлцуулахад шаардагдах цэвэр усны хэмжээ. Усны бохирдлын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тооцоход ашиглана.



АНУ-д нэг хүнд хоногт ногдох усны мөр 6,800 л байгаа нь Хятадынхаас гурав дахин их байна. Усны мөрийг **ногоон, цэнхэр, саарал** гэсэн 3 төрлөөр тооцно.

### Хоол хүнсний усны мөр

Та өглөө бүр нэг аяга кофе уудаг гэж бодвол нийт 140 л ус “хэрэглэнэ”. Аяганы хэмжээ 100 гр боловч кофены шош ургуулах, үйлдвэрлэх, савлах, тээвэрлэх шат дамжлага бүрт ус зарцуулагдах ба нийт хэмжээ 140 л болно. Энэ нь аяга кофены “усны мөр” юм. Энэ нь Англи зэрэг хөгжилтэй орны нэг хүнд ногдох хоногийн усны дундаж хэрэглээтэй ойролцоо юм.

Нэг кг үхрийн мах үйлдвэрлэхэд ойролцоогоор 15,000 л ус (93% ногоон, 4% хөх, 3% саарал усны ул мөр) зарцуулагдана гэдэг нь махны чиглэлийн үйлдвэрлэлийн дэлхийн дундаж хэмжээ бөгөөд үхрийн тэжээлийн торөл, найрлага, гарал үүсэл зэрэг хүчин



Эх сурвалж: Berger et al; Water Footprint Network, “Water footprints of nations”; Friends of the Earth/Trucost; WFN, “The water footprint of cotton consumption”; WFN, “The water footprint of wood for lumber; pulp, paper; fuel and firewood”

усжуулалтад хэт их ашигласнаас болжээ. Тарьсан хөвөнг хураах, боловсруулж утас ээрэх (ээрмэлийн үйлдвэр), даавуу болгх, будах, оёдлын үйлдвэрт цамц хийх зэрэг бүх шат дамжлагад орсон нийт усыг ойролцогоор тооцож үзвэл 2,900 л орчим болно. Үйлдвэрийн тог, цахилгаан, дэлгүүрт хүргэх тээврийн хэрэгсэлд ашиглах шатахуун үйлдвэрлэхэд ч ус зарцуулагдана. Ийнхүү бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шууд ба шууд бусаар зарцуулж буй усны нийт хэмжээ нь усны мөр болно.

Усны мөрийн сүлжээ (Water Footprint Network) байгууллагаас гаргасан жагсаалтаар хоногт нэг хүнд ногдох усны мөрөөр тэргүүлэх 5 орны тоонд Монгол улс багтсан нь усны нөөц багатай манай орны хувьд усны хэрэглээ хэт их байгааг харуулж байна.

1. Монгол: 10,000 л ус
2. Нигери: 9,600 л
3. Болив: 9,500 л
4. АНЭУ: 8,600 л
5. АНУ: 7,800 л



E. Батчулуун (2018).  
Ус ба боловсрол.  
Геофорум. 2018. №2



NASA видео-Арал тэнгис яагаад ширгэх олсон бэ?

Хөвөнгийн тариалан

# 6

## СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮНЭЛГЭЭ

Энэ бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийн талаарх сургалтад ашиглаж болох арга зүй болон хичээл дээр, хичээлээс гадуур хийх үйл ажиллагаа, үнэлгээний жишиг даалгавар оруулав.

### ТҮЛХҮҮР ҮГС

|                                 |                                 |
|---------------------------------|---------------------------------|
| Activity                        | Үйл ажиллагаа                   |
| Air pollutants                  | Агаар бохирдуулагчид            |
| Assessment                      | Үнэлгээ                         |
| Ecological footprint Calculator | Экологийн мөрийг тооцоолох      |
| Carbon footprint Calculator     | Нүүрстөрөгчийн мөрийг тооцоолох |
| Compost making methods          | Нигшингэ (компост) бэлтгэх арга |
| Rangeland management            | Бэлчээрийн менежмэнт            |
| Smart shopping                  | Ухаалаг худалдан авалт          |
| Plastic waste management        | Хуванцар хог хаягдлын менежмэнт |
| Water Footprint Calculator      | Усны мөрийн тооцоолуур          |
| Water footprint                 | Усны мөр                        |
| Waste segregation               | Хог хаягдлыг ялгах              |



## Цэнхэр дэлхий ногоон амьдрал .

үйлдвэрлэл юунд хүргэж буй, түүний хор уршиг, бусад зүйлсийн хоорондох холбоо хамаарлыг судлахад тусална.

### **Кейс судлах: Атакамын цөлийн хувцсан овоо**

Чили улсын нутагт ба Андын нурууны баруун талд Номхон далайн эрэг дагуу 1,600 км сунаж оршдог, 105,741 км<sup>2</sup> талбайтай Атакамын цөл нь дэлхийн хамгийн хуурай, хамгийн эзгүй газрын нэг. Зэсийн баялгаараа танигдсан Атакамын цөл бас нэг зүйлээрээ “алдарших” болсон нь тэнд байдаг “илүүдэл хувцасны овоо” юм. Хуучин хувцаснаас гадна загвар нь хоцрогдсон, худалдагддагүй, эсвэл илүүдэл болсон төрөл бүрийн шинэ хувцасны хамгийн том хогийн цэг энд бий. Хог болсон эдгээр хувцас Атакамын цөлд ирэх хүртлээ урт зам туулна. Ихэнх нь хөдөлмөрийн хөлс багатай Хятад, Бангладешт үйлдвэрээс гарч, Европ, Америкийг “туулсаар” сүүлд нь Өмнөд Америкийн орнуудад хүрдэг. Энд ч эс борлох хувцас эцэс сүүлдээ Чили рүү зөөгдөн, эзгүй газрыг “бараадсан” нь Атакамын цөл юм. Чилийн хойд хэсгийн Альто Хоспицио чөлөөт бүс дэх Икике боомтоор жил бүр хэдэн сая тонн хувцас энд ирдэг. 2022 онд 44 сая тонн хувцас орж иржээ (National Geographic). Үүнээс зарим нь Өмнөд Америкийн улсуудад зарагдаж, үлдсэн нь Атакамын цөл рүү ачигдана. Энд овоорсон хувцасны ихэнх нь байгальд задардагтүй, синтетик материалыар хийгдсэн байдал нь бохирдлын эх үүсвэр болж байна. Синтетик материал байгальд задрах хүртлээ 200-аад жил зарцуулна. НҮБ-ын 2019 оны тайланд дурдсанаар, 2000-2014 оны хооронд дэлхийн хувцасны үйлдвэрлэл хоёр дахин өссөн бөгөөд дэлхийн хаягдал усны 20 хувь, хүлэмжийн хийн ялгарлын 8 хувийг эзэлж байна.




*“Atacama desert clothing dump”* гэж бичин интернэтээс хайлт хийж энэ кейстэй холбогдох бусад мэдээлэл ба зураг ашиглаж болно.



## Жишээ Б. Усны мөрийг тооцоолох

**Алхам 1.** Усны нөөц, усны хүрэлцээ хангамж ба нэг хүнд ногдох цэнгэг усны талаар төрөл бүрийн мэдээлэл авах линк: <https://ourworldindata.org/clean-water-sanitation>



Нэг хүнд ногдох цэнгэг усны нөөц, 2019 оноор

<https://ourworldindata.org/grapher/renewable-water-resources-per-capita?tab=map>

**Алхам 2.** Монгол орны хэмжээнд дээрх мэдээллийг авахаар бол улсын нэр (Country) гэсэн хэсгээс сонгоно.

**Алхам 3.** Хүн тус бүр өөрийн усны мөрийг тооцоолж гаргаад харьцуулан хэлэлцүүлэг зохионо.

**Алхам 4.** Видео үзэх: ЮНЕСКО, Ус хаана байдаг вэ?: <https://www.waterfootprint.org/water-footprint-2/what-is-a-water-footprint/#direct-and-indirect>

**Ашиглах линк: Усны мороо тооцоолох:** <https://www.watertcalculator.org/>

<http://www.footprintcalculator.org/en/quiz/0/food/category>

Calculate your footprint гэсэн цэс дээр дарна.



**Усны морийн тухай:** [The Water Footprint Network https://www.waterfootprint.org/](https://www.waterfootprint.org/)

Хоол, хүнс ба ахуйн хэрэглээгээ тооцон дам зарцуулагдсан усны хэмжээг гаргасан дараах хүснэгтийг ажиглан, сургалт, үйл ажиллагаандaa ашиглана уу.




## Жишээ В. Хуванцарын хэрэглээнээс үүсэх бохирдол


Бидний өдөр тутмын хэрэглээний нэг хэсэг бол хуванцар ба түүний төрлийн зүйлс юм. Энэ нь энгийн гялгар уут, ус ундааны сав, нэг удаагийн хуванцар аяга халбага, сав баглаа боодол зэргээс эхэлнэ. Хуванцар зүйлсийг шатаавал химийн хортой бодисдиоксин ялгарна. Газар булсан ч байгальд задрах хүртлээ олон зуун жил зарцуулна. Интерактив мэдээлэл ашиглах зарим жишээ үзье.

**Алхам 1.** Ашиглах линк: <https://ourworldindata.org/plastic-pollution>

**Алхам 2.** Эндээс “Interactive Charts on Plastic Pollution” гэсэн хэсгээс сонгоно.



**Алхам 3.** График, хүснэгтэн болон зурган мэдээллийг ашиглан асуудал дэвшүүлэх, хамаарлын зураглал зохиох, төсөл бол овсруулах байдлаар ажиллаж болно.



Эх сурвалж: <https://ourworldindata.org/plastic-pollution>

**Алхам 4.** Далай тэнгисийн усанд маш их хэмжээний хог хаягдал зөөгдөн ордог. Номхон далайн хойд ба өмнөд хэсэгт том талбай эзлэх “хогон цагираг” (Great Pacific Garbage Patch) үүсдэг ба 2023 оны байдлаар 1.6 сая км<sup>2</sup> талбай

мянга, сая сая тонноор хог болон хаягддаг. АНУ-д л гэхэд жилд 40-өөд сая тн цаас, 50-аад сая тн хуванцар хаягддаг ажээ.

1. Цахилгаан хөдөлгүүрт машин худалдаж авах нь танд болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад ямар ашигтай вэ? Жишээ нь: Гибрид хөдөлгүүрт (түлшин хөдөлгүүр ба цахилгаан мотортой) машин энгийн машинаас дуу багатай г.м.
2. Унадаг дугуй ашиглах нь ямар ашигтай вэ? Дараах 4 төрөл тус бүрт тохирох жишээ 3-ыг бичнэ.
  - 1) Эрүүл мэндэд үзүүлэх нөлөө
  - 2) Замын хөдөлгөөнд үзүүлэх нөлөө
  - 3) Хувь хүний болон өрхийн эдийн засагт үзүүлэх нөлөө
  - 4) Байгаль орчинд үзүүлэх нөлөө

### **ҮЙЛ АЖИЛЛАГАА 11. Нигшингэ (компост) бэлтгэх**

“Нигшингэ” (compost) бол хамгийн хямд буюу үнэ мөнгө орохгүйгээр, гарын доорх материал ашиглан хийдэг байгалийн бордоо бөгөөд хөрс сайжруулж, хөрсний ялзмаг бий болгосноор үржил шимийг дээшлүүлдэг. Учир нь хөрс хэдийчинээ ялзмаг сайтай, агаартай байна, төдий чинээ ургамал сайн ургана.

Хөрсийг бүрдүүлэгч үндсэн 4 бүрэлдэхүүн нь ус, агаар, органик бодис (ургамалын үлдэгдэл), шороо юм. Нигшингэ хийхэд ч үүний нэгэн адил, ургамал, ногооны үлдэгдэл (хүнсний ногоо болон жимсний хальс, навч г.м), шороо болон өндөгний хальс (шороог орлоно), тэдгээрийг сийрэгжүүлэн агаар оруулах ба чийгшүүлэх ус орно.

**Гэрийн похцолд нигшингэ хэрхэн хийх вэ?**  
Хэрэглэгдэх зүйлс



| Ногоон материал                  | Бор материал            | Хийж болохгүй зүйлс                  |
|----------------------------------|-------------------------|--------------------------------------|
| - Жимсний хальс, хаягдал         | - Хатсан навч           | - Max, өөх тос агуулсан бүтээгдэхүүн |
| - Хүнсний ногооны хальс, хаягдал | - Модны тайрдас, холтос | - Ургамлын материал                  |
| - Өндөгний хальс                 | - Үртсэн цаас           | - Мал амьтны баас, ялгадас           |
| - Кофены шаар                    | - Дэрс                  | - Хогийн ургамал                     |
| - Өвс, ногооны хаягдал           | - Модны үртэс           | - Сүү, сүүн бүтээгдэхүүн             |

#### **Бэлтгэх заавар**

- **Кофены шаар:** Кофены шаарыг бордоонд хийвэл азотын агууламж нэмэгдэнэ. Азотоор баялаг хөрсөнд хүнсний ногоо тариалахад тохиромжтой. Өөрөө хэрэглэсэн эсвэл кофе шопоос шаарыг нь цуглуулан ашиглаж болно.

## ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШИГ ДААЛГАВАР

### ДААЛГАВАР 1. Цаг агаар ба уур амьсгалын ялгаа

а) Цэгийн оронд “цаг агаар” ба “уур амьсгал” гэсэн үгийн аль тохиорохыг иөхөж бичээрэй.

- Өнөөдрийн .....: Температур 23°C, бороотой.
- Энэтхэгийн зүүн эргээр халуун орны муссоны.....зонхилено.

б) Дараах өгүүлбэрийн утга цаг агаар (ЦА) ба уур амьсгал (УА)-ын алиныг нь илэрхийлж чадах вэ? Тэмдэглээрэй.

Монголд өвөл тэсгим хүйтэн, зундаа халуун. Хур тунадасны ихэнх нь 7-8 дугаар сард унадаг.

Энэ долоо хоногт их халах тул наршихаас сэргийлээрэй.

Өглөө орж байсан бороо татарч, тэнгэр гийлээ.

Австралид 6, 7 сард явахаар бол дулаан хувцас хэрэг болно.

Зундаа хуурайвтар дулаан. VII сард дунджаар +30°C дулаан

Өглөө шороон шуургатай, салхи 5-8 м/с, үдээс хойш салхины хурд буурна

Итали зун халуун, хуурай тул жуулчид их очдог.

Өглөө агаарын температур +12°C үдээс хойш +18°C

Сингапур, Тайланд, Вьетнам, Лаос улсаар аялахаар бол дулаан, зузаан хувцас хэрэггүй.

Улаанбаатарт тэнгэр бүрхэг, 15 цаг хүртэл бороо орно. Салхи баруунаас 2-3 м/сек. Агаарын температур 24°C. Харьцангуй чийг 95%. Агаарын даралт 961 гектопаскаль.

7 хоногийн эхээр Даланзадгадад дулаан байна.

Маргааш цасан шуургатай тул малаа хашаанаас гаргаад хэрэггүй.

Индонезид жилийн турш температурын хэлбэлзэл бараг байхгүй.


### ДААЛГАВАР 2. Агаарын температурын өөрчлөлтийг судлах

1850 оноос хойш дэлхийн агаарын температурын өөрчлөлтийг харуулсан дараах график уншиж, хүснэгтийг бөглөөрэй (Зургийг дараах линкээс татаж авах тул жижиг хэмжээтэй оруулав)

|            |      |      |      |      |      |      |      |      |      |
|------------|------|------|------|------|------|------|------|------|------|
| Он         | 1850 | 1880 | 1900 | 1920 | 1940 | 1960 | 1980 | 2000 | 2023 |
| Температур |      |      |      |      |      |      |      |      |      |

Температурын өөрчлөлтийг 40, 40 жилээр гаргаж харьцуулсан дүгнэлт гаргаарай.

## Цэнхэр дэлхий ногоон амьдрал .



Тайлбар: <https://ourworldindata.org/grapher/temperature-anomaly> линк рүү орж зураг дээр курсорaa гүйлгэн, харж болох ба хүснэгт ба график гэх мэт аль ч хэлбэрээр ашиглаж болно. Жишээ нь: хөндлөн тэнхлэгийн дагуу курсораа хөдөлгөөд 1987-2023 оны хоорондох хугацааг сонговол температурын өөрчлөлт нь дараах байдлаар гарч байна.




Table (хүснэгт) гэсэн дээр дарвал сонгосон хугацааны доторх өөрчлөлт гарах ба холбогдох бүх мэдээллийг excel хэлбэрээр татаж авч, зааж буй хичээлдээ хэрэглээрэй



### ДААЛГАВАР 3. Хүлэмжийн нөлөө

- Шаталтын үр дүнд утаа ялгаруулдаг түүш аль нь вэ? Ялгаж бичээрэй. (Төмрийн хүдэр, нүүрс, алт, байгалийн хий, газрын тос, хөнгөн цагаан)
- Улаан лооль, өргөст хэмхийн үнийг төмс, байцаа зэрэг бусад хүнсний ногооныхтой харьцуулахад өндөр байdag. Үүний учир юу вэ?

**Хоол хүнсний усны мөрийг тооцоолоход ашиглах**

|   |                          |   |                                  |  |                                 |
|---|--------------------------|---|----------------------------------|--|---------------------------------|
|    | 250 г<br>зөөхий<br>475 л |    | 180 г                            |    | 20 г<br>иогурт<br>237 л         |
|    | 60 г 238 л               |    | 1 ш<br>50 л                      |     | 80 г<br>218 л                   |
|   | ширхэг чинжүү 76 л       |    | 1 ш<br>сонгино<br>27 л           |    | 80 г элсэн<br>чихэр<br>11 л     |
|  | 100 г сироп<br>22 л      |  | 100 г<br>оливын<br>тос<br>1443 л |   | 250 г<br>сармисны соус<br>930 л |
|  | 1ширхэг<br>алим<br>125   |  | 100 г бяслаг<br>318 л            |  | 1 зүсм<br>талх<br>160 л         |
|  |                          |  |                                  |   | 0.5 л<br>175 л                  |

**Г. Усны мөр-Хувцас үйлдвэрлэл** (Нэг ширхэгээр) Та ямар төрлийн хэдэн ээлжийн хувцастай вэ? Тоймтойгоос нь сонгон хэдий хэмжээний ус “өмсөж” байгаагаа тооцоолж нийлбэрийг гаргаарай.



Хөвөн даавуун цамц  
2,900 л



Жинсэн өмд  
10,000 л



Хөвөн даавуун фудволка  
2,700 л



Хос арьсан гутал 8,000 л



Хос пүүз 8,000 л



Хос арьсан ботинк: 7,600 л



Арьсан цүнх 17,100 л



Ноосон цамц 6500 л



Дотуур өмд 850 л



Арьсан хүрэм 32,000 л



Малгайтай ноосон цамц 3,350 л



Хос оймс 750л

## Д. ҮНДСЭН УХАГДАХУУНЫ ТАЙЛБАР

**Агаар мандал** Дэлхийн гадна талаар хүрээлж буй хийн бүрхэвч.

**Агаарын температур** Агаар хэр зэрэг халуун юмуу хүйтэн байгааг илтгэх хэмжүүр.

Агаарын температур нь ургамал, амьтан, усны ууршилт, харьцангуй чийг, салхины хурд, тунадасны хэлбэр, хэмжээнд нөлөөлнө.

**Агаарын тунадас** Агаараас газрын гадарга дээр унаж буй усны бүх төрөл. Хатуу (цас), шингэн (бороо, шүүдэр, хяруу г.м.) хэлбэртэй байна.

**Агаарын чийг** Агаарт агуулагдах усны уурын хэмжээ. Агаар хуурай юмуу чийглэг байх нь ахуй амьдрал болон ургамалд нөлөөлдөг.

**АЗОТЫН ИСЛҮҮД** Азотоос үүссэн бохирдуулагч хийнүүд. Түлшний шаталтаас болж үүснэ.

**Аэрозолууд (PM)** Хатуу ба шингэн хэлбэрээр агаарт орших тоос шороо, PM (Particular matter)-ээр хэмжигдэнэ.

**Байгаль дахь усны эргэлт** Нарны энерги болон хүндийн хчүний нөлөөгөөр үүсэх агаар мандал, усан мандал, газрын давхаргын хоорондох усны тасралтгүй шилжилт.

**Бохирдуулагч** Агаар, ус, хөрсөнд нэвтрэн ордог элдэв төрлийн бохирдуулагч бодисууд.

**Бэлчээрийн даац** Бэлчээрийн нэгж талбайд тодорхой хугацааны турш барьж болох мал, өвсөн тэжээлтэн амьтны тоогоор илэрхийлэгддэг хэмжигдэхүүн.

**Бэлчээрийн талхлагдал** Байгалийн болон хүний үйл ажиллагаанаас болж ургамлын бүрхэвч тачир сийрэг болж, мал иддэггүй өвс ургамал урган, бэлчээрийн шимт чанар багасах үйл явц.

**Доторх агаарын бохирдол** Өрөө тасалгаа, гэр орон, ажлын байр зэрэг дотор орчин дахь агаарын бохирдол.

**Дэлхийн дулаарал** Хүлэмжийн хийн нөлөөгөөр дэлхийн гадарга орчмын агаарын температур нэмэгдэж буй үзэгдэл. Гол нь хүний үйл ажиллагаа нөлөөлнө.

**Нүүрстөрөгчийн мөр** Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр шууд ба шууд бус замаар үүсэх нүүрстөрөгч агуулсан хийн хэмжээ.

**Нүүрсхүчлийн хий** Түлшний шаталтаас болж ялгарсан хортой хий.

**Озоны давхарга** Агаар мандлын дээд хэсэгт буюу 22-25 км-ийн өндөрт оршдог хийн бүрхэвч. Нарнаас ирэх хэт ягаан түяаг шингээн дэлхийн гадаргыг хамгаалагчийн үүрэг гүйцэтгэнэ.

**Салхи** Агаарын даралтын зөрүүнээс болж үүсдэг агаарын хэвтээ чиглэлийн хөдөлгөөн. Даралтын зөрөө их байвал салхины хүч их, зөрөө бага байвал

### Нэмж ашиглах бусад материалууд (QR code-oop орно)

Бүх видео үзэх: <https://www.climate.gov/teaching/video>

Агаарын бохирдол, тест: <https://climate.nasa.gov/quizzes/air-we-breathe-quiz/>

Арктик ба Антарктидийн ялгаа видео: <https://www.youtube.com/watch?v=Z5VRoGTF60s>

Дэлхийн температур нэмэгдсэнээс гарч буй үр дагавар 1.28 мин: <https://www.britannica.com/science/greenhouse-effect/images-videos>

Нүүрсхүчлийн хий ба хүлэмжийн нөлөө ба түүний нөлөө-2.17 мин: <https://www.britannica.com/science/greenhouse-effect/images-videos>

Хойд түйлын мөсөн бүрхэвч багасаж байгааг үзүүлсэн анимейшн: [https://svs.gsfc.nasa.gov/vis-a000000/a004400/a004435/sealIce\\_noGraph\\_0000\\_1080p30.webm](https://svs.gsfc.nasa.gov/vis-a000000/a004400/a004435/sealIce_noGraph_0000_1080p30.webm)

Уур амьсгалын үйлчилгээний систем: <http://climate-service.mn/climateservice/index.php?menu-item=2&product=1>

Уур амьсгалын тухай суурь ухагдахуун: Teaching Climate: <https://www.climate.gov/teaching/climate>

Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ухай <https://www.youtube.com/watch?v=-n4A0BssFd0>

Уур амьсгалын тест: <https://climate.nasa.gov/explore/interactives/quizzes>

Усны мөр тооцоолох: <https://www.watercalculator.org/>; <https://www.waterfootprint.org/resources/interactive-tools/personal-water-footprint-calculator/>; [https://www.waterfootprint.org/resources/The-WaterFootprintAssessmentManual\\_English.pdf](https://www.waterfootprint.org/resources/The-WaterFootprintAssessmentManual_English.pdf)

Хичээлд ашиглах хөтөч: <https://teachers-climate-guide.fi/mathematics/>

Causes of Climate Change: <https://www.un.org/en/climatechange/science/causes-effects-climate-change>

CLIMATE ALLIANCE. Zoom kids on the move: <http://www.zoom-kidsforclimate.eu/home.html?&L=0>

Climate Change: Arctic sea ice summer minimum: <https://www.climate.gov/news-features/understanding-climate/climate-change-arctic-sea-ice-summer-minimum>

Climate Literacy Quiz: <https://cleanet.org/clean/literacy/climate/quiz.html>

Energy Literacy Quiz: <https://cleanet.org/clean/literacy/energyquiz.html>

Middle School Curriculum: <https://climatechange.stanford.edu/curriculum/middle-school-curriculum>

NASA Scientific Visualization Studio <https://svs.gsfc.nasa.gov/4435>

NOAA Climate.gov graph: <https://www.climate.gov/news-features/understanding-climate/climate-change-arctic-sea-ice-summer-minimum>

Stanford Doerr School of Sustainability: <https://climatechange.stanford.edu/curriculum>

Teaching climate: <https://www.climate.gov/teaching/all>

Understanding global change <https://ugc.berkeley.edu/about/UNESCO Climate change education:https://www.unesco.org/en/education-sustainable-development/climate-change>

UNESCO Learning objectives: <https://developmenteducation.ie/wp-content/uploads/2017/07/Sustainable-development-goals-learning-objectives-2017.pdf>

<http://www.zoom-kidsforclimate.eu/home.html?&L=0>

[https://issuu.com/unclearn/docs/resource\\_guide\\_on\\_integrating\\_cc\\_in](https://issuu.com/unclearn/docs/resource_guide_on_integrating_cc_in)

<https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000219752>

<https://www.britannica.com/science/greenhouse-gas/images-videos>

<https://www.climate.gov/media/9087>

